# СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА

Денверийн гудамж 13, 11 дүгээр хороолол,
7 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, 14190, Утас: (976) 7007 0109
Цахим шуудан: info@sbd.gov.mn
Цахим хуудас: www.sbd.ub.gov.mn


2025.12.26 № 02//3362

танай 2025.12.04 -ны № 01/571 -т

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАРТ

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 354 дүгээр тогтоолоор батлагдсан Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгох тухай журмын дагуу дүүргийн 7 дугаар хорооны иргэн, өвлөн уламжлагч Д.Баярхуягийн материалыг хүргүүлж, шагналд нэр дэвшүүлж байна.

Хавсралт 19 хуудастай.

Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газар
Удирдлага
Засаг даргын орлогч
Удвал Өнөрцэцэг
2025.12.26 15:20




ДУУТ УРЛАН

# Д.Баярхуяг

Уран бүтээлч | Дархан | Өв соёл тээгч

Д.Баярхуяг нь Монгол Улсын соёлын биет бус өв, үндэсний язгуур урлагийг өвлөн уламжилж, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр 1987 оноос өнөөг хүртэл тасралтгүй, идэвхтэй уран бүтээл туурвиж буй өвлөн уламжлагч юм.

## Үндсэн мэдээлэл

Ургийн овог: Дуут
Овог: Дэндэв
Нэр: Баярхуяг
Төрсөн он, сар, өдөр: 1971 оны 05 дугаар сарын 19
Нас: 49
Хүйс: Эрэгтэй
Яс, угсаа: Халх
Регистрийн дугаар: ХН71051917
Оршин суугаа хаяг: Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, 11-р хороолол, 5А байр, 49 тоот
Утас: 9908-2459, 9903-2459
Цахим шуудан: bayarhuyag-dendev@gmail.com

---

## Намтар түүх

Дуут овгийн Дэндэвийн Баярхуяг нь 1971 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Улаанбаатар хотын Хоёрдугаар амаржих газарт төрсөн. Халх ястай, эрэгтэй. 1989 онд нийслэлийн 37 дугаар дунд сургуулийг төгсөж, 1990–1992 онд хилийн цэрэгт алба хаасан. Улмаар Барилгын техник мэргэжлийн сургуулийг мастерийн зэрэгтэй төгссөн.

Д.Баярхуяг нь өвөг эцгээсээ дарханы ур ухааныг өвлөж, 1981 оноос эхлэн ард түмний соёл иргэншил, түүх дурсгалын үнэ цэн бүхий соёлын биет өвийг бүтээж, олон нийтэд сурталчлахад идэвхтэй оролцсоор ирсэн. Тухайлбал, 1992 онд Төрийн 9 хөлт цагаан тугны жанжин оройг урлах ажилд гар бие оролцож, нийслэлийн Засаг даргын өрөөний тугын догийг хийж гүйцэтгэсэн нь түүний ур чадвар, бүтээлийн амжилтын эхлэл болсон.

1993 онд "Дуут" урланг үүсгэн байгуулж, үндэсний өв соёлыг хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлэх үйлсийг тасралтгүй эрхэлж байна. Дуут Урлангийн бүтээлүүд нь Монгол шатар, домбо, гүнгэрваа, цацлын халбага, идээний цар, айрагны хувин, халбага сэрээ зэрэг ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн бөгөөд уламжлалт гоо зүй, түүх, соёлын элементүүдийг шингээсэн, дахин давтагдашгүй уран хийцтэй. Мөн модон сийлбэр, эсгий урлал, арьсан урлалаар үйл ажиллагаагаа өргөжүүлж, уламжлалт загварыг цаг үетэй нийцүүлэн сайжруулсан шинэчлэл хийж байна.

Бүтээгдэхүүний онцлог нь зэс, гууль, мөнгө зэрэг эрүүл мэндэд тустай үнэт металуудыг ашиглаж, хүний энергийг тэнцвэржүүлэн эрдэс бодисын дутагдлаас сэргийлэх, хелико бактер, цайрын дутагдал зэрэг сөрөг нөлөөг бууруулах давуу талтай. Тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн байгальд ээлтэй технологийг ашиглан бүтээгдэхүүн урлах нь Монгол Улс болон дэлхий нийтийн эрүүл мэнд, анагаах ухаанд хувь нэмэр оруулж буй үйл ажиллагаа юм.

Д.Баярхуяг нь Монгол шатрын гарал үүслийг судлан уран бүтээлдээ дүрслэн, 37 гаруй нэр төрлийн шатрыг урлан, шатрын үнэ цэнийг тодорхойлох ажилд Монголын шатрын холбоо, дэлхийн шатрын холбоо, Соёлын яам, сургалт судалгааны байгууллага, шатар судлаачидтай хамтран ажиллаж байна. Нийгмийн хариуцлагын хүрээнд сургууль, цэцэрлэгүүдэд үндэсний хэв загвартай шатаруудыг хямд өртгөөр нийлүүлж, түүх, үлгэр домог, туульсын сэдэвтэй 30 гаруй төрөл загварыг боловсруулан бэлэн болгосон.

Мөн Д.Баярхуяг телевиз, хэвлэл мэдээллийн байгууллагуудын олон удаагийн нэвтрүүлэг, соёлын кино, түүхийн контентод уран дарханаар оролцож, “Хийморь”, “2000” зэрэг уран сайхны киноны үндэсний өв, соёлын агуулгыг шингээх бүтээлч ажил хийсэн.

Дуут овгийн Д.Баярхуяг нь Монголын үндэсний соёлын биет бус өвийг хамгаалах, хадгалах, амьд хэлбэрээр түгээн дэлгэрүүлэх олон талт, туршлагатай уран бүтээлч гэдгээрээ үнэлэгддэг билээ.

---

## Оролцсон томоохон үйл ажиллагаанууд

Түүний бүтээлүүдийг дотоод, гадаадын 50 шахам үзэсгэлэнд 40 гаруй бүтээлээрээ улсаа төлөөлөн сурталчилж, гадаад харилцаа, соёлын хамтын ажиллагааны арга хэмжээнүүдэд амжилттай оролцсон. Тухайлбал:

- 2012 онд Монгол–БНХАУ–ОХУ-ын гурван улсын эдийн засгийн коридорын хүрээнд зохион байгуулагдсан үзэсгэлэнд амжилттай оролцсон
- 2013 онд “Улаанбаатар түншлэл–2013” олон улсын намрын үзэсгэлэнд үндэсний өв, соёлыг түгээн дэлгэрүүлэгчээр шалгарч цом, хүндэт өргөмжлөл хүртсэн
- 2014–2019 онуудад БНХАУ, ОХУ болон дотоодын олон арга хэмжээнд үндэсний өв соёлоо түгээн дэлгэрүүлсэн.
- 2022 онд Саудын Араб улсад Өв соёлын болон би даасан шатрын үзэсгэлэн гаргаж Саудын хунтайжаас талархалын бэлэг хүртсэн.
- 2023 онд Франц улсын Нант хотын түүхийн музейд зохион байгуулагдсан “Чингис хаан: Монголчууд дэлхийг өөрчилсөн нь” үзэсгэлэнд 20 гаруй бүтээлээр оролцсон.
- 2024 онд Нүүдэлчин Монгол наадамд оролцон шилдэг оролцогч өргөмжлөл.
- 2025 онд XVII жарны хөхөгчин могой жилийн сар шинийн баярыг тохиолдуулан “Өв тээсэн үнэ цэн-Сар шинийн үнэт бэлэг-” үзэсгэлэн Монголын Үндэсний музейд энэ сарын 11-нээс эхлэн үргэлжилж байна. Тус үзэсгэлэнг Соёл, спорт аялал жуулчлал, залуучуудын яамны дэмжлэгээр Монголын Үндэсний музей, Дуут урлал ХХК, Монголын шатрын холбоо хамтран зохион байгуулсан.
- 2025 онд Төрийн их баяр наадмаар Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам болон бусад 4 хүндэтгэлийн өргөөг тохижуулж удаа дараа оролцсон.
- 2025 онд Нүүдэлчин Монгол наадамд оролцон шилдэг оролцогч өргөмжлөл.

- 2025 онд Хятад улсад зохион байгуулагдсан "Дэлхийн соёлын өдрүүд" арга хэмжээнд Монгол улсаа төлөөлөн урилгаар оролцсон. Мөн түүнчлэн Хятад улсад суух Монгол улсын элчин сайдын яаманд өв соёлоо түгээн дэлгэрүүлэх зорилгоор Монгол шатраа байрлуулсан. Энэ нь олон улсад суугаа элчин сайдын яаманд Монгол шатараа байрлуулсан 3 дах удаагын үйл явдал юм.
- 2025 онд Эрдэнэд хотод зохион байгуулагдсан Зэс фестивалд 3 дах жилдээ оролцон тэргүүн байр эзэлсэн.
- 2025 онд Дотоодын 13, Гадаадын 3 үзэсгэлэн худалдаанд оролцон Монгол улсын соёлын өвийг сурталчилсаар байна.
- 2025 онд "Design vitality" наадамд оролцсон.
- 2025 онд Ерөнхийлөгчийн ивээл доор Төрийн ордон, Чингис хааны музейд зохион байгуулагдсан "Монгол дархан уламжлал шинчлэл" арга хэмжээнд үзэсгэлэнгээ гаргаж оролцсон.

---

## Шагнал

Түүний хөдөлмөр, бүтээлийг төр, засаг болон олон нийтийн зүгээс өндрөөр үнэлж:

- 2013, 2015 онд СБД-ийн "Хөдөлмөрийн алдар" медаль.
- 2014 онд МУЗГ-ын "Үйлдвэрийн тэргүүний ажилтан" тэмдэг.
- 2022 онд СБД-ийн "Хүндэт тэмдэг", Улаанбаатар хотын Захирагчийн жуух бичиг.
- 2024 онд Соёлын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг.
- 2024 онд Шатрын холбооноос Биеийн тамир спортын 100 жилийн медаль.
- 2025 онд ЮНЕСКО–Бүтээлч хот төслийн "Бүтээлч иргэн" тэргүүн байр.

гэсэн нэр хүндтэй шагналуудаар шагнагдсан.

---

## Холбогдох

Утас: 9908-2459, 9903-2459

Имэйл: bayarhuyag-dendev@gmail.com

DUUT URLAN

MONGOLIAN NATIONAL CRAFT




- 2022 онд Саудын Араб улсад Өв соёлын болон би даасан шатрын үзэсгэлэн гаргаж Саудын хунтайжаас талархалын бэлэг хүртсэн



- 2023 онд Франц улсын Нант хотын түүхийн музейд зохион байгуулагдсан “Чингис хаан: Монголчууд дэлхийг өөрчилсөн нь” үзэсгэлэнд 20 гаруй бүтээлээр оролцсон




- 2025 онд XVII жарны хөхөгчин могой жилийн сар шинийн баярыг тохиолдуулан “Өв тээсэн үнэ цэн-Сар шинийн үнэт бэлэг-” үзэсгэлэн Монголын Үндэсний музейд боллоо. Тус үзэсгэлэнг Соёл, спорт аялал жуулчлал, залуучуудын яамны дэмжлэгээр Монголын Үндэсний музей, Дуут урлал ХХК, Монголын шатрын холбоо хамтран зохион байгуулсан.



- 2025 онд Төрийн их баяр наадмаар Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам болон бусад 4 хүндэтгэлийн өргөөг тохижуулж удаа дараа оролцсон.



- 2025 онд Хятад улсад зохион байгуулагдсан “Дэлхийн соёлын өдрүүд” арга хэмжээнд Монгол улсаа төлөөлөн урилгаар оролцсон. Мөн түүнчлэн Хятад улсад суух Монгол улсын элчин сайдын яаманд өв соёлоо түгээн дэлгэрүүлэх зорилгоор Монгол шатраа байрлуулсан. Энэ нь олон улсад суугаа элчин сайдын яаманд Монгол шатараа байрлуулсан 3 дах удаагын үйл явдал юм.



- 2025 онд Нүүдэлчин Монгол наадамд оролцон шилдэг оролцогч өргөмжлөл.



- 2025 онд Эрдэнэд хотод зохион байгуулагдсан Зэс фестивалд 3 дах жилдээ оролцон тэргүүн байр эзэлсэн



- 2025 онд “Design vitality” наадамд оролцсон.



- 2024 онд Соёлын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг



- 2025 онд Ерөнхийлөгчийн ивээл доор Төрийн ордон, Чингис хааны музейд зохион байгуулагдсан “Монгол дархан уламжлал шинчлэл” арга хэмжээнд үзэсгэлэнгээ гаргаж оролцсон.



- 2024 онд Шатрын холбооноос Биеийн тамир спортын 100 жилийн медаль



- 2025 онд ЮНЕСКО–Бүтээлч хот төслийн “Бүтээлч иргэн” тэргүүн байр гэсэн нэр хүндтэй шагналуудаар шагнагдсан.

## СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧ Д. БАЯРХУЯГЫН АЖИЛ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Дэндэв овогтой Баярхуяг нь 1971 оны 05 дугаар сарын 19-ны өдөр Улаанбаатар хотын хоёрдугаар амаржих газар төрсөн. 1989 онд нийслэлийн 37 дугаар дунд сургуулийг суралцан төгссөн. 1990-1992 онд хилийн цэрэгт алба хааж ирээд Барилгын техник мэргэжлийн сургуулийг мастерийн зэрэгтэй төгссөн.

Д. Баярхуяг нь өвөг эцгээсээ дарханы ур ухааныг өвлөж 1981 оноос эхлэн ард түмний соёл иргэншил, түүх дурсгалын үнэ цэн соёлын биет өв болох олон бүтээлүүдийг хийж бүтээж, олон нийтэд сурталчлах ажилд оролцсоор байна. Тухайлбал, 1992 онд Төрийн 9 хөлт цагаан тугны жанжин оройг хийлцэх ажилд гар бие оролцон хийж гүйцэтгэсэн. Мөн нийслэлийн засаг даргын өрөөний тугын догь хийж гүйцэтгэсэн.

Тэрээр уран бүтээлийн хувьд дотоод гадаадын 50 шахам үзэсгэлэнд 40 гаруй бүтээлээр улсаа төлөөлөн сурталчлах бүтээлүүдээрээ оролцож гадаад харилцаа, соёлын хамтын ажиллагааны үйл ажиллагаануудын үзэсгэлэн хүлээн авалт, ЖДҮ эрхлэгчдийн үзэсгэлэнгүүдэд удаа дараалан амжилттай оролцсоор байна.

2012 онд МУЗГ, НЗДТГ,МҮХАҮТ, НЖДҮГ болон БНХАУ, ОХУ-ын хамтарсан гурван улсын коридорын үеэр Монгол улсаас зохион байгуулсан үзэсгэлэнд амжилттай оролцож дараа дараагийн олон арга хэмжээнүүдэд оролцох урилгуудыг хүлээн авсан.

2014-2019 онуудад БНХАУ, ОХУ, дотоодод зохион байгуулагдсан арга хэмжээнүүдэд үндэсний өв соёлоо түгээн дэлгэрүүлэх зорилгоор олон удаа амжилттай оролцсон.

2022 онд Саудын Араб-д суугаа элчин сайдтай хамтран Араб-д зохиогдсон ЖДҮ эрхлэгчдийн үзэсгэлэнд оролцсон.

2023 оны 10 сард Франц улсын Нант хотын түүхийн музейд зохион байгуулагдсан Чингис хаан: “Монголчууд дэлхийг өөрчилсөн нь” үзэсгэлэнд 20 гаруй бүтээлээр хамтран оролцсон.

Сүүлийн жилүүдэд АНУ, ОХУ, БНХАУ, ФРАНЦ зэрэг улсуудад соёлын яамны дэмжлэг, үйл ажиллагаа үзэсгэлэнгүүдэд амжилттай оролцсоор байна.

Д.Баярхуяг нь 1983 онд Дуут Урлан ХХК-ийг үүсгэн байгуулж түүх соёлын онцлогыг тусгасан дахин давтагдашгүй ур хийцлэлээр бүтээгдэхүүн бий болгож соёлын өвийг хадгалж түгээн дэлгэрүүлэх зорилготой ажиллаж байна. Дуут Урланы бүтээгдэхүүнүүд болох Монгол шатар, домбо, гүнгэрваа, цацлын халбага, идээний цар, айрагны хувин, халбага сэрээ зэрэг нь ахуйн амьдралын хэрэгцээнд нэн шаардлагатай бүтээгдэхүүний ангилалд хамаардаг ч илүү хээнцэр хийцлэлтэй. Мөн модон сийлбэр, эсгий урлал, арьсан урлалаар үйл ажиллагаагаа өргөжүүлэн тэлж. уламжлалт загваруудыг цаг үетэйгээ нийцүүлэн илүү сайжруулсан загвараар урлаж байна.

Бүтээгдэхүүний онцлог нь эрүүл мэндэд тустай метал болох зэс, гууль, мөнгө зэрэг үнэт металаар хийгддэг. Эдгээр металууд нь хүний биеийн энергийг

тэнцвэржүүлж эрдэс бодисын дутагдлаас сэргийлж, хелико бактер цайрын дутагдал зэрэг сөрөг нөлөөг бууруулдаг давуу талтай.

Д.Баярхуяг нь тогтвортой хөгжлийн зорилт болох байгальд ээлтэй технологийг ашиглаж бүтээгдэхүүн урладаг нь улс үндэстэн болон дэлхий нийтийн эрүүл мэнд анагаах ухааны хөгжилд хувь нэмрээ оруулж буй үйл билээ.

Д.Баярхуяг нь Монгол шатрын гарал үүслийн талаар судалж, уран бүтээлдээ дүрсэлж, 37 гаруй нэр төрлийн шатруудыг урлаж шатрын үнэ цэнийг тодорхойлох ажилд Монголын шатрын холбоо болон дэлхийн шатрын холбоо, Соёлын яам болон сургалт судалгааны байгууллага, шатар судлаачидтай хамтран ажиллаж байна.

2013 онд НЗДТГ,МҮХАҮТ-ын хамтран зохион байгуулсан УЛААНБААТАР ТҮНШЛЭЛ 2013 Олон улсын намрын үзэсгэлэн яармагт Үндэсний өв уламжлал, соёлыг түгээн дэлгэрүүлэгчээр шалгарч цом, хүндэт өргөмжлөлөөр шагнагдсан.

2014 онд МУЗГ, Хөдөлмөрийн яамнаас зохион байгуулсан “Бүтээлч Монгол”-2014 арга хэмжээнд идэвхи, санаачлагатай манлайлан оролцсоныг үнэлэн Хөдөлмөрийн яамны сайдын өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдсан байна.

2013,2015 онуудад Нийслэлийн СБД-ийн “Хөдөлмөрийн алдар”, ойн медалиар шагнуулав

2014 онд МУЗГ-шагнал “Үйлдвэрийн тэргүүний ажилтан”-тэмдэгээр шагнуулсан.

2022 онд СБД-ийн “Хүндэт тэмдэг” медалиар шагнуулсан.

2022 онд Улаанбаатар хотын Захирагчийн “Жуух бичиг”-мөнгөн шагналаар шагнуулсан.

2024 онд Соёлын тэргүүний ажилтан

Д.Баярхуяг нь үндэсний соёлын өвийг хамгаалах, хойч үедээ өвлүүлэн үлдээх үнэ цэнэтэй бүтээгдэхүүнийг урлаж, уран бүтээлийн ажлын дадлага туршлага бүхий олон талт бүтээлч үйл ажиллагаатай уран бүтээлч юм.

Дүүргийн 7 дугаар хорооны иргэн, Соёлын биет бус өвийг өвлөн тээгч, Дуут урлан ХХК-ны захирал:



# ШАГНАЛУУД


ub 2013
ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ
УЛААНБААТАР ТУНШЛЭЛ 2013
AUSTRALIA


SME'2019
ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ


ӨРГӨМЖЛӨЛ


SME's 2019
INTERNATIONAL TRADE FAIR

# ШАГНАЛУУД




















中俄蒙






МОНГОЛЫН УРАН ДАРХАНЫ
ТҮМЭН ЭРДЭНЭС НЭГДСЭН ХОЛБОО







































DUUT URLAN

MONGOLIAN NATIONAL CRAFT

# ТАНИЛЦУУЛГА

ДАХИН ДАВТАГДАШГҮЙ ТАНСАГ ЗЭРЭГЛЭЛ
ГАР ХИЙЦ 13 ТӨРЛИЙН ШАТРЫН ИЖ БҮРДЭЛ БА БУСАД БҮТЭЭЛҮҮД



# DUUT URLAN

CHESS SET

# ЭРТ ҮЕ ЗАГВАР ШАТАР



ЭНЭХҮҮ ЗАГВАР ДЭЭР МАНАЙ ЭРИНИЙ ӨМНӨХ ҮЕИЙН ОЛДВОР, ХАДНЫ ЗУРАГ, БУГАН ЧУЛУУН ХӨШӨӨ, СҮГ ЗУРАГ ЗЭРЭГ ДҮРСЭЛЛҮҮДЭЭС СЭДЭВЛЭН БҮТЭЭВ.

## Хөлөг болон суурийг сольж болдог

| Урт | Өргөн | Өндөр | Жин | Дан хөлөг жин |
|---|---|---|---|---|
| 60cm | 60cm | 32.5cm | 13.1кг | 4,18кг |

| | | |
|---|---|---|
| Зэс | Cu | 58.72% |
| Цайр | Zn | 32.56% |
| Алт | Au | 7.94% |
| Ниоби | Nb | 0.39% |
| Мөнгө | Ag | 0.32% |
| Никель | Ni | 0.05% |
| Манган | Mn | 0.01% |

ШАР ТАЛ

| Ботготой тэмээ суурь | |
|---|---|
| Ди. Тэмээ суурь | ı |
| Өндөр | 7.5cm |
| Жин | 0.24кг |

| Хуц (эр хонь) | |
|---|---|
| Диаметр | 4.3cm |
| Өндөр | 4.9cm |
| Жин | 0.08кг |

| | | |
|---|---|---|
| Зэс | Cu | 78.59% |
| Цайр | Zn | 17.68% |
| Мөнгө | Ag | 3.40% |
| Ниоби | Nb | 0.23% |
| Никель | Ni | 0.08% |
| Манган | Mn | 0.01% |

ХАР ТАЛ

# АТИЛЛА БА РОМ ШАТАР

ГУУЛИН ЦУТГАМАЛ, ХАР ЦАГААН ТАЛЫГ 999 СОРЬЦЫН АЛТ, МӨНГӨӨР БҮРЖ ЯЛГАСАН , ХУШ МОДОН, ДАХИН ДАВТАГДАШГҮЙ ГАР ЗОРМОЛ СИЙЛБЭРТЭЙ ХӨЛӨГ ТАВЦАНТАЙ, ДЭЛХИЙН СТАНДАРТ ХЭМЖЭЭТЭЙ, УДАМ ДАМЖСАН УРЛААЧИЙН ӨВӨРМӨЦ БӨГӨӨД СЭТГЭЛ ТАТАМ ИЖ БҮРДЭЛ ЮМ. ХҮННҮ ГҮРНИЙ ОМГУУДЫН ХААН, ЦЭРГИЙН ЖАНЖИН АТИЛЛА ХААНЫ ДҮРЭЭР БҮТЭЭГДСЭН ЭНЭХҮҮ ШАТРЫН ЦАГААНЫ ТАЛЫН ХӨЛГҮҮД НЬ XI ЗУУНЫ ХҮННҮ ГҮРНИЙ ЦЭРГИЙН БАЙР БАЙДЛЫГ ХАРУУЛСАН. ХАРЫН ТАЛЫН ХӨЛГҮҮД НЬ ТУХАЙ ҮЕИЙН РОМЫН ЭЗЭНТ ГҮРНИЙ ЦЭРЭГ, ДАЙНЫ БАЙДЛААР ДҮРСЛЭГДСЭН.







# НҮҮДЭЛЧИН МОНГОЛ

МОНГОЛ ОРНЫ ОН ЦАГ, ӨВ СОЁЛ, АЖ БАЙДЛЫГ ДҮРСЛЭН УРЛАСАН, ГУУЛИН ЦУТГАМАЛ, ХАР ЦАГААН ТАЛЫГ 999 СОРЬЦЫН АЛТ, МӨНГӨӨР БУРЖ ЯЛГАСАН, ХУШ МОДОН, ДАХИН ДАВТАГДАШГҮЙ ГАР ЗОРМОЛ СИЙЛБЭРТЭЙ ХӨЛӨГ ТАВЦАНТАЙ, ДЭЛХИЙН СТАНДАРТ ХЭМЖЭЭТЭЙ, УДАМ ДАМЖСАН УРЛААЧИЙН ӨВӨРМӨЦ ИЖ БҮРДЭЛ ЮМ.





# ЧИНГИС ХААН ЗАГВАР ШАТАР

ЧИНГИС ХААНЫ ҮЕ ДЭХ СОЁЛЫН СОЛИЛЦОО
НАЙРАМДАЛ



Хөлөг болон суурийг сольж болдог

| Урт | Өргөн | Өндөр | Жин | Дан хөлөг жин |
|---|---|---|---|---|
| 60cm | 60cm | 32.5cm | 13.1kг | 4.18kг |

| | | |
|---|---|---|
| Зэс | Cu | 58.72% |
| Цайр | Zn | 32.56% |
| Алт | Au | 7.94% |
| Ниоби | Nb | 0.39% |
| Мөнгө | Ag | 0.32% |
| Никель | Ni | 0.05% |
| Манган | Mn | 0.01% |

ШАР ТАЛ

| Толгоо суурь | |
|---|---|
| Диаметр | 4.8cm |
| Өндөр | 7.5cm |
| Жин | 0.24kг |

| Хүү | |
|---|---|
| Диаметр | 4.3cm |
| Өндөр | 4.9cm |
| Жин | 0.08kг |

| | | |
|---|---|---|
| Зэс | Cu | 78.59% |
| Цайр | Zn | 17.68% |
| Мөнгө | Ag | 3.40% |
| Ниоби | Nb | 0.23% |
| Никель | Ni | 0.08% |
| Манган | Mn | 0.01% |

ХАР ТАЛ







МОНГОЛ УЛС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА

Наадамчдын зам 1200, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976-11) 32 39 77, 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2025.12.30 № 01/8600

танай __________ -ны № __________ -т

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЗАХИРАЛ Г.ЭНХБАТ ТАНАА

"Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгох тухай журам"-ын дагуу шалгуур үндэслэл хангаж буй өвлөн уламжлагчдын мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Х.Нямбаатар Х.НЯМБААТАР

1725141030

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠨᠡᠶᠢᠰᠯᠡᠯ ᠦᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ

ᠴᠠᠬᠢᠮ ᠬᠠᠭᠤᠳᠠᠰᠤ : www.ulaanbaatar.mn
[illegible]
[illegible]

[illegible] ᠳ [illegible]

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠳᠤ
ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠭ᠃ ᠵᠠᠨᠳᠠᠨᠱᠠᠲᠠᠷ ᠲᠠᠨ᠎ᠠ

ᠰᠠᠨᠠᠯ ᠬᠦᠷᠭᠦᠯᠬᠦ ᠲᠤᠬᠠᠢ

[illegible]

ᠬᠠᠪᠰᠤᠷᠤᠯᠲᠠ :: [illegible] :: ᠬᠠᠭᠤᠳᠠᠰᠤ ᠲᠠᠢ ::

ᠨᠡᠶᠢᠰᠯᠡᠯ ᠦᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠪᠥᠭᠡᠳ
ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ ᠶᠢᠨ ᠵᠠᠬᠢᠷᠤᠭᠴᠢ

ᠬ᠃ ᠨᠢᠶᠠᠮᠪᠠᠭᠠᠲᠤᠷ

1725091434

Нийслэлийн Засаг даргын 2025 оны
...12.......дүгээр сарын ...30-ны өдрийн
...01/8600........ дугаар албан бичгийн
хавсралт

ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ ӨВЛӨН
УЛАМЖЛАГЧДЫН НЭРС

| Д/д | Дүүрэг | Нэр дэвшигчдийн тоо | Нэр дэвшигчийн мэдээлэл |
|---|---|---|---|
| 1 | Баянгол дүүрэг | 6 | Гүен Балданцэрэн /ГЮ47020919/ |
| 2 | | | Хонгор Уртнасан /ПЭ56091001/ |
| 3 | | | Баасанхүү Цэрэндагва /НЭ90020515/ |
| 4 | | | Далхаа Эрдэнэзуу /УУ65011351/ |
| 5 | | | Төмөрхүү Батмөнх /ЧП46021533/ |
| 6 | | | Равжаа Санжсүрэн /ОЭ53091572/ |
| 7 | Баянзүрх дүүрэг | 2 | Алтангэрэл Дагзмаа /РЭ51110901/ |
| 8 | | | Эрдэнэцогт Баатаржав /УС72031617/ |
| 9 | Налайх дүүрэг | 1 | Энхтуяа Хүрэлбаатар /ДП75031311/ |
| 10 | Сонгинохайрхан дүүрэг | 1 | Дурма Балган /ОЭ60072973/ |
| 11 | Сүхбаатар дүүрэг | 1 | Дэндэв Баярхуяг /ХН71051917/ |
| 12 | Чингэлтэй дүүрэг | 1 | Задь Цэнгэлсайхан /ТЖ56020501/ |
| 13 | Хан-Уул дүүрэг | 1 | Лхагвасүрэн Лхамрагчаа /ОЮ81040814/ |